



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑᠑ оны ᠐᠑ сарын ᠑᠒ өдөр

Дугаар А/᠒81

Мандалговь

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн
шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэр (Айраг-2-238)-д байршилтай “Санаа заяа” ХХК (РД:3427897)-ны үйлчилгээний зориулалттай 1258 м.кв (᠐,1га) газраас иргэн Жамсранжавын Нарангэрэл (ЗЮ:58᠐62506)-д 650 м.кв (᠐,06га) газрыг шилжүүлж, үлдсэн 608 м.кв (᠐,06га) зориулалтаар нь Санаа заяа” ХХК (РД:3427897)-д тус тус 16 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх аж ахуй нэгж, иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/09 дугаар захирамжийн Санаа заяа” ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000310152 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111207